**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үенч сумын төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/009/НА-СТА-ТТЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2026 он | Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: М.Энхжаргал<br>Утас:70432545 Цахим хаяг: enkhjargalm@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

***Товчилсон үгийн жагсаалт*** ...... **2**
***1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ*** ...... **3**
***2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ*** ...... **5**
*2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан* ...... 5
*2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан* ...... 5
*2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан* ...... 6
*2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан* ...... 7
*2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан* ...... 8
***3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ*** ...... **9**
*3.1 Төлбөрийн акт* ...... 9
*3.2 Зөвлөмж* ...... 9
***4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ*** ...... **11**
***5.ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ*** ...... **12**

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.23 № 270

танай ______ -ны № ______ -т

ҮЕНЧ СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.БАТХИШИГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Үенч сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Үенч сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Үенч сум нь тайлант онд 3,830 хүн амтай, жилийн эцсийн мал тооллогоор 153,484 толгой мал тоолуулжээ.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Үенч сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 1,932.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 349.3 мянган төгрөг буюу 22.0 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Тайлант онд 3,361.5 сая төгрөгийн зардал батлагдаж гүйцэтгэлээр 3,158.1 сая төгрөгийг зарцуулснаас 1,262.1 сая төгрөгийг урсгал зардалд, 665.7 сая төгрөгийг тогтмол зардалд 1,160.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 70.1 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулжээ.

**Бусад асуудлын хэсэг**

2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 бодлогын 51 зорилтын хүрээнд 78 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, дэвшүүлсэн зорилт гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга 80.1 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | 1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,145,789.56 | 1,581,913.24 |
| 2 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 621,945.88 | 699,478.46 |
| 3 | 1.1.3 АВЛАГА | 398,181.92 | 697,146.43 |
| 4 | 1.1.4 УРЬДЧИЛГАА | 85,779.95 | 85,779.95 |
| 5 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 39,881.82 | 99,508.4 |
| 6 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,260,004.89 | 3,146,925.37 |
| 7 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,260,004.89 | 3,146,925.37 |
| 8 | 1.2.2.02 Биет хөрөнгө | 3,248,486.89 | 3,135,407.37 |
| 9 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 11,518 | 11,518 |
| 10 | 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 4,405,794.45 | 4,728,838.61 |
| 11 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | 20,673.54 | 36,800.77 |
| 12 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 20,673.54 | 36,800.77 |
| 13 | 2.1.1.03 Өглөг | 20,673.54 | 36,800.77 |
| 14 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,385,120.91 | 4,692,037.84 |
| 15 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | 4,385,120.91 | 4,692,037.84 |
| 16 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | 4,028,302.56 | 4,028,302.56 |
| 17 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | 79,696.45 | 386,613.37 |
| 18 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 277,121.9 | 277,121.9 |
| 19 | 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 4,405,794.45 | 4,728,838.61 |

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 4,060,955.37 | 3,588,452.97 |
| 2 | 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 1,499,514.84 | 1,907,930.92 |
| 3 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | 1,318,047.96 | 1,550,639.9 |
| 4 | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | 1,361,436.84 | 1,594,055.85 |
| 5 | 1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -43,388.87 | -43,415.96 |
| 6 | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 38,763.92 | 41,371.24 |
| 7 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 142,702.96 | 315,919.78 |
| 8 | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 773,693.89 | 1,680,522.06 |
| 9 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 447,945.56 |
| 10 | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,787,746.64 | |
| 11 | 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,351,797.84 | 3,177,140.48 |
| 12 | 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 3,351,797.84 | 3,177,140.48 |
| 13 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,325,903.84 | 3,075,881.11 |
| 14 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 784,854.95 | 920,228.25 |
| 15 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 97,413.03 | 109,443.72 |
| 16 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 712,404.17 | 702,839.73 |
| 17 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 1,214,524.88 | 960,671.93 |
| 18 | 1.1.2.01.1.05 Нормативт зардал | 553.7 | 80 |
| 19 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 30,988.5 | 13,460.49 |
| 20 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 16,570.1 | 18,837.6 |
| 21 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 78,225.19 | 37,219.17 |
| 22 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 390,369.32 | 313,100.2 |
| 23 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 25,894 | 101,259.37 |
| 24 | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 709,157.53 | 411,312.5 |
| 25 | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.0 | 110,000 |
| 26 | 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | 0.0 | -110,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 27 | 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 709,157.53 | 301,312.5 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 3,359,004.4 | 3,365,196.62 |
| 2 | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 1,499,514.84 | 1,907,930.92 |
| 3 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 1,318,047.96 | 1,550,639.9 |
| 4 | 1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -43,388.87 | -43,415.96 |
| 5 | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 38,763.92 | 41,371.24 |
| 6 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 142,702.96 | 315,919.78 |
| 7 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 35,237.3 | 30,563.29 |
| 8 | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 15,346.29 | 16,407.85 |
| 9 | 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 92,119.37 | 268,948.63 |
| 10 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 95,892.17 | 1,457,265.71 |
| 11 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 95,892.17 | 105,239.94 |
| 12 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 447,945.56 |
| 13 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 904,080.2 |
| 14 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,763,597.39 | 0.0 |
| 15 | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,926,984.64 | 2,057,336.86 |
| 16 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 1,926,984.64 | 2,057,336.86 |
| 17 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,901,090.64 | 1,956,077.49 |
| 18 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 783,442.24 | 916,449.32 |
| 19 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 98,122.9 | 114,838.5 |
| 20 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 712,404.17 | 708,498.59 |
| 21 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 71,058.84 | 44,009.55 |
| 22 | 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | 553.7 | 653.2 |
| 23 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 30,988.5 | 14,494 |
| 24 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 16,570.1 | 19,177.6 |
| 25 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 52,099.13 | 49,170.11 |
| 26 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 135,851.07 | 88,786.62 |
| 27 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 25,894 | 101,259.37 |
| 28 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 1,432,019.75 | 1,307,859.76 |
| 29 | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 1,227,131.63 | 1,160,177.18 |
| 30 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,227,131.63 | 1,160,177.18 |
| 31 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 1,227,131.63 | 1,160,177.18 |
| 32 | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -1,227,131.63 | -1,160,177.18 |
| 33 | 1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 72,150 | 70,150 |
| 34 | 1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 166.88 | 0.0 |
| 35 | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -72,316.88 | -70,150 |
| 36 | 1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 132,571.24 | 77,532.58 |

| | | | |
|---|---|---|---|
| 37 | 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 489,374.64 | 621,945.88 |
| 38 | 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 621,945.88 | 699,478.46 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Мянган төгрөгөөр

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,671,327.38 | 3,671,327.38 |
| 2 | 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 4,636.0 | 4,636.0 |
| 3 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,675,963.38 | 3,675,963.38 |
| 4 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 709,157.53 | 709,157.53 |
| 5 | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,385,120.91 | 4,385,120.91 |
| 6 | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,385,120.91 | 4,385,120.91 |
| 7 | 1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 5,604.43 | 5,604.43 |
| 8 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,390,725.34 | 4,390,725.34 |
| 9 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 301,312.5 | 301,312.5 |
| 10 | 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 4,692,037.84 | 4,692,037.84 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Мянган төгрөгөөр

| № | Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| **1** | **1** | **3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **3,361,538.6** | **3,321,425.2** |
| **2** | **11** | **3.1.01.1.1 Татварын орлого** | **1,568,246.4** | **1,907,930.9** |
| 3 | 110 | 3.1.01.1.1.1 Орлогын албан татвар | 1,426,562.2 | 1,592,011.1 |
| 4 | 1100 | 3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар | 1,422,678.2 | 1,594,055.9 |
| 5 | 110001 | 3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 377,914.70 | 451,069.46 |
| 6 | 110002 | 3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого | 18,000.10 | 42,964.25 |
| 7 | 110003 | 3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого | 50,000.00 | 37,388.06 |
| 8 | 110004 | 3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого | - | 60.12 |
| 9 | 110008 | 3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого | 67,500.00 | 58,220.20 |
| 10 | 1101 | 3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (43,416.0) | (43,416.0) |
| 11 | 110101 | 3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (33,512.60) | (33,512.60) |
| 12 | 113 | 3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар | 47,300.0 | 41,371.2 |
| 16 | 118 | 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж | **141,684.2** | **315,919.8** |
| 17 | 1180 | 3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 29,600.0 | 30,563.3 |
| 21 | 1181 | 3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр | 26,784.2 | 16,407.9 |
| 23 | 1182 | 3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 85,300.0 | 268,948.6 |
| **27** | **12** | **3.1.01.1.2 Татварын бус орлого** | **1,793,292.2** | **1,413,494.3** |
| 28 | 120 | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 15,000.0 | 77,240.0 |
| 32 | 122 | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | 874,212.0 | 404,174.1 |
| 35 | 123 | 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 904,080.2 | 932,080.2 |
| **37** | **II** | **3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,361,538.5** | **3,253,695.3** |
| 38 | 21 | **3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,949,525.4** | **2,023,368.1** |
| 39 | 210 | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,949,525.4 | 2,023,368.1 |
| 40 | 2101 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 919,853.3 | 916,449.3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 45 | 2102 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 114,838.5 | 114,838.5 |
| 51 | 2103 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 711,591.8 | 708,498.6 |
| 55 | 2104 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 44,290.5 | 43,731.5 |
| 59 | 2105 | 3.1.01.2.1.1.5 Нормативт зардал | 727.4 | 653.2 |
| 61 | 2106 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 14,968.5 | 14,494.0 |
| 64 | 2107 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 20,022.4 | 19,177.6 |
| 66 | 2108 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 53,467.7 | 46,871.2 |
| 73 | 2109 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 58,468.9 | 57,395.0 |
| 76 | 213 | 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,296.4 | 5,689.2 |
| | | | | 95,570.00 |
| 83 | 22 | **3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,315,403.2** | **1,160,177.2** |
| 86 | 223001 | 3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө | - | - |
| 87 | 23 | **3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **96,609.9** | **70,150.0** |
| 88 | 230001 | 3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл | - | - |
| 91 | 7 | 3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 1,556,987.6 | 67,729.8 |
| 92 | 4 | 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 610,472.9 |
| 93 | 5 | 5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 678,202.7 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(мянган төгрөгөөр)

| Дансны код | Дансны нэр, төрөл | 2024.12.31 | 2025.12.3 |
|---|---|---|---|
| **1** | **1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | 110,412.1 | **43,771.5** |
| **12** | **1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 110,412.1 | **43,771.5** |
| 122 | 1.1.1.1.1.1 Тусламжийн орлого | 110,412.1 | 43,771.5 |
| 1221 | 1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/ | 110,412.1 | 43,771.5 |
| 12213 | 1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого | 110,412.1 | 43,771.5 |
| **II** | **1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **98,939.1** | **33,968.7** |
| **21** | **1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ** | **98,939.1** | **33,968.7** |
| | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | |
| | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | |
| 210 | 1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | **98,939.1** | **33,968.7** |
| | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | |
| 2104 | 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | **21,456.2** | **278.0** |
| | Тээвэр шатахуун | 21,456.2 | 278.0 |
| 2108 | 1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 11,759.7 | **2,299.0** |
| 2109 | 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 65,723.2 | **31,391.7** |
| 213 | 1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | |
| 2132 | 1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | | 0 |
| **22** | **1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **0** |
| 2200 | 1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр | - | 0 |
| **4** | **1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **11,473.0** | **9,802.8** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТТЗ-ын нэгтгэлд хамруулан гүйцэтгэсэн ТТЗ, ОНХС, ХХС-гийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 97,925.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 31,591.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

**Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд:**

- ✓ Тайлант хугацааны үр дүнг үр дүнгийн тайланд зөрүүтэй–428.7 мянган төгрөг,
- ✓ Хугацаа хэтэрсэн зээлийн алданги, тайлант жилийн хүүгийн орлогыг тусгаагүй-10,512.6 мянган төгрөг,
- ✓ Зээлдэгчийн төлсөн зээлийн төлбөрийг программд бодит дүнгээс зөрүүтэй хаасан -20,650.0 мянган төгрөг,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д ‘’аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх’’ заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 29,753.5 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 29,753.5 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1,370.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 28,383.5 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 3.1 Төлбөрийн акт

Засаг даргын захирамжаар иргэдэд дэмжлэг болгон шатахууны бичиг тарааж 1,370.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд зарцуулалтын анхан шатны баримт дутуу, хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д ”орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно” 4.7.5-д “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”; 4.7.6-д “ Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

### 3.2 Зөвлөмж

### 3.2.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

**3.2.1.1 Илрүүлэлт:** ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэх 17.4 сая төгрөгийн үнэ бүхий 3 нэр төрлийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн бүртгэлд тусгаагүй, эд хөрөнгийн тооллого хийж тооцоо бодоогүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүргийг хүлээнэ”, 20,2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэээгүй орхисон/,*

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгийн асуудлыг сумын ИТХ-ын шийдвэр гаргуулж эхний хагас жилийн тайланд бүртгэх.

**3.2.1.2 Илрүүлэлт:** ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-д урьдчилгаа олгохдоо банкны урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх",Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-д "Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 278-р тогтоолыг мөрдөж ажиллах.

**3.2.1.3 Илрүүлэлт:** ОНХС-ийн хөрөнгөөс хөтөлбөр, арга хэмжээнд нярвын дансаар дамжуулан хөтөлбөр арга хэмжээнд 10,945.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд зарцуулалтын анхан шатны баримт дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын хоёр дугаар зүйлийн 3-д "Мөнгөний нярав орлого, зарлагын баримтууд, мөнгө олгохыг хүссэн өргөдөл зэргийг үндэслэн баримт тус бүрээр өдөр бүр бэлэн мөнгөн гүйлгээний тайланг 2 хувь үйлдэн, 1 хувийг холбогдох баримтуудын хамт нягтлан бодогчид тушааж, үлдэх хувийг өөртөө үлдээнэ." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг зориулалтын дансаар, анхан шатны баримт бүрдэл хангагдсан тохиолдолд гүйлгээ хийх дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл* */мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 12 |
| Хоршоо хөгжүүлэх сан | Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчдэд ногдох хуримтлагдсан хүү, алдангийг дутуу тооцсон | 1 | 10,512.60 | 1 | 10,512.60 | | | 1 | 10,512.60 | | | | |
| Хоршоо хөгжүүлэх сан | Тайлант хугацааны үр дүнг санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан. | 1 | 428.70 | 1 | | 1.00 | 428.70 | 1 | 428.70 | | | | |
| Хоршоо хөгжүүлэх сан | 2023 онд зээлдэгчийн төлсөн зээлийн төлбөрийг программд бодит дүнгээс зөрүүтэйгээр хааж бүртгэсэн | 1 | 20,650.00 | 1 | 20,650.00 | | | 1 | 20,650.00 | | | | |
| **ДҮН** | | **3** | **31,591.30** | **3** | **31,162.60** | **1** | **428.70** | **3** | **31,591.30** | **0** | **0.00** | **0** | **0.00** |

*4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* */мянган төгрөгөөр/*

| **Аудитад хамрагдсан байгууллагын нэр** | **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс: Төлбөрийн акт** | | **Үүнээс: Албан шаардлага** | | **Үүнээс: Зөвлөмж** | | **Үүнээс: Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| ОНХС | Хөтөлбөр, үйл ажиллагааны зардлыг нярвын дансаар дамжуулан зарцуулсан | 1 | 10,945.00 | | | | | 1 | 10,945.00 | | |
| ОНХС | Үндсэн хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй | 1 | 17,438.50 | | | | | 1 | 17,438.50 | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ОНХС | ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-д урьдчилгаа олгохдоо банкны урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр олгосон | 1 | 0.00 | | | | | 1 | 0.00 | | |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сангаас иргэдэд дэмжлэг нэрээр шатахуун олгосон | 1 | 1370 | 1 | 1370 | | | | | | |
| **Нийт дүн** | | **4.00** | **29,753.50** | **1.00** | **1,370.00** | **0.00** | **0.00** | **3.00** | **28,383.50** | **0.00** | **0.00** |

## 5.ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТТЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |